ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИНД ЭНГИЙН ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ
(ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ)

Б. Товуусүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг,
А. Пагма, Б. Хатантуул

Агуулга

1. Европ, Азийн зарим орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи эрх зүйн зохицуулалт
2. Энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийн тухай” хуулиудад хэрхэн тусгасан тухай харьцуулалт
3. Монгол Улс, ОХУ, Япон, Швед, БНКУ, БНЧУ-ын хөдөлмөр эрхлэлтийн хуулийн энгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи эрх зүйн зохицуулалтын харьцуулалт
4. Ашигласан материал:
    1. Эрх зүйн актууд:
        - Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, Ажилгүйдлын тэтгэмжийн тухай хууль
        - ОХУ-ын 1991 онд батлагдсан “Оросын Холбооны Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай” хууль, 1999 онд батлагдсан “Төрийн нийгмийн тусламжийн тухай” хууль, “Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай”
        - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” 1966, “Хөдөлмөр эрхлэлтийн аюулгүй байдлын тухай хууль” 1947, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005
        - БНКаз Улсын 2001 оны “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, 2005 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаллын тухай” хууль, 1997 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, өндөр насны нийгмийн тэтгэмжийн тухай” хууль
        - Швед Улсын“Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах тухай акт” (1982), “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг ялгаварлан гадуурхахыг хориглох акт”(1999) “Адил тэгш хөдөлмөр эрхлэх боломж акт“ (1991), “Ажилгүйдлийн даатал” (1997), “Ажилгүйдлийн сан” (1997) зэрэг эрх зүйн актууд
        - Чех Улсын Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль/2004/
    2. Ном:
        - Ч. Дагвадорж. Нийгмийн хамгаалал: онол арга зүй, харьцуулалт УБ. 2004 он.
        - П. Бямбацэрэн, Ч. Дагвадорж. Нийгмийн хамгаллын тулгамдсан асуудлууд 2000 он.

* * *

Европ, Азийн зарим орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи эрх зүйн зохицуулалт

Хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх мэт төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх гурван үндсэн үүргийг нийгмийн хамгаллын систем гүйцэтгэдэг. “Дэлхийн нийгмийн хамгаллын хөтөлбөр” /Social Security Program Throughout the World буюу “SSPTW” нь 178 орны нийгмийн хамгаалын асуудлыг нэгдсэн системд оруулсан. Энэ хөтөлбөрийг АНУ-ын нийгмийн хамгаллын захиргаа/ U.S.Social Security Administration “SSA”, /Олон улсын нийгмийн хамгаллын холбоо/ Internatiol Social Security Association “ISSA”/ хамтарч боловсруулдаг бөгөөд гишүүн орнуудын тайлан мэдээг

үндэслэн 2-3 жил тутам шинэчлэгдэж байдаг.

Энэ хөтөлбөрт Ази, Номхон далайн - 51, Европын 45, Америкийн 37, Африкийн 45 нийт 178 орнууд хамрагдаж нийгмийн хамгааллын асуудлууд нь нэгтгэгдсэн боловч Монгол улс одоогоор хамрагдаж чадаагүй байна. Үүнийг манай улсад зах зээлийн шилжилтийн үйл явц үргэлжилж байгаагаар тайлбарлаж болох боловч Орос, Киргиз, Казахстан, Вьетнам, Камбож, Польш, Унгар зэрэг пост социалист улс орнууд дэлхийн нийгмийн хамгааллын системд нэгдсэн байна.

Өндөр хөгжилтэй орнуудад хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудал төлөвшиж, ядуурал, ажилгүйдэл зэрэг асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрджээ. Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилт нь нийгмийн зөвшилцөл дээр суурилсан сайтар бодож боловсруулсан нийгмийн хамгааллын системтэй холбоотой гэдэгтэй эрдэмтэд, судлаачид сүүлийн жилүүдэд санал нэгдэж байна.

Судалгаанд хамрагдсан Ази, Европын зарим орны хувьд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хөдөлмөр эрхлэлтийн тухай болон хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг хуулиудад хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх заалт нийтлэг тусгагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дор дурдсан үйл ажиллагааны чиглэлийг нийтлэг баримталж байна. Үүнд:

а/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

б/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

в/ Ажилгүйдлийн тэтгэмж олгох

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар улс орнууд өөрийн онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалттай байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, тэтгэмжийн хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэлэгийн хэмжээг үзүүлэв.

№	Ангилал	Сар бүрийн мөнгөн төлбөрийн хэмжээ (руб.)	Нийгмийн үйлчилгээний төлбөрийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ (НҮТ=641 руб.)	Төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ	Үнэгүй эмээр хангагдах болон үнэ төлбөргүй сувилуулах эрхийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ
1	Тахир дутуугийн I групп (3 түвшин)	**2162.00**	**1521.00**	**2091.00**	**1592.00**
2	Тахир дутуугийн II групп (2 түвшин)	**1544.00**	**903.00**	**1473.00**	**974.00**
3	Тахир дутуугийн III групп (1 түвшин)	**1236.00**	**595.00**	**1165.00**	**666.00**
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд	**1544.00**	**903.00**	**1473.00**	**974.00**

5	Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин тогтоогоогүй тахир дутуу хүмүүс	**772.00**	**131.00**	**701.00**	**202.00**

Мөн “Оросын Холбооны улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” Холбооны хуульд заасан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууцаар хангагдах, орон сууцны хөлс төлөхөд хөнгөлөлт үзүүлдэг болно.

Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулинд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгасан байдал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль нь 2001 онд батлагдсан бөгөөд хуулийн зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хуулийн 5,1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дор дурдсан төрөлтэй байна гэжээ.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ
- Ажилгүйдлийн тэтгэмж олгох

Эдгээр үйл ажиллагааны төрлүүдэд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрхэн тусгасныг дараах хүснэгтээр тоймлон илэрхийлье.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл		**Энгийн иргэд**	**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**
5.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих **үйлчилгээ**	5.2.1Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судлах, хөдөлмөр эрхлэгүй иргэдийн судалгаа гаргах, тэднийг бүртгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах	7.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол явуулж иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ. 7.2 Энэ хуулийн 7,1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.	

	1.1.2 Ажилд зуучлах	8.1 Хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ОН-ийн алба бүртгэж ажилд зуучлана. 8.2 ААНБ-ын хөдөлмөр зуучлалын алба нь төр захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр ажилд зуучлах үйлчилгээ гүйцэтгэж болох бөгөөд тайлан мэдээгээ хөдөлмөр эрхлэлтийн албанд ирүүлнэ. 8.3 Ажлын байрны захиалга, түүнд тавих шаардлагын таөлаарх мэдээлэл ил тод байна. 8.4Ажилд зуучлах төрийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна.	8.5 Хөдөлмөр эрхлэлтийн алба нь ажилд жуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил олгогчтой гэрээ байгуулж. хэрэгжилтэд хяналт тавина.
	1.1.3 Мэргэжил олгох, давтан сургалтанд хамруулах	9.1.1Эмзэг бүлэгт хамрагдах ажилгүй иргэн 9.1.2 Ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй иргэн 9.1.3 Осол хурц хордлого, мэрэгжлээс шалтгаалах өвчний улмаас мэргэжлээ өөрчлөхийг хүссэн ажил хайгч ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн 9.1.4 Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй болсон иргэн 9.1.5 Тухайн онд ЕБСийн 8,10 анги төгссөн, эсхүл хугацаат цэргийн албанаас халагдсан ажил сургууль гүй иргэн 9.1.7 Сургууль завсардсан, насанд хүрээгүй иргэн	9.1.6 Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн
5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих **арга хэмжээ**	1.1.1 Нөхөрлөл, хоршооны хэлбэр, хувираа болон өрхийн АА эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	10.1 Хувираа болон өрхийн АА, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ХЭДС-аас дараахь дэижлэг үзүүлнэ. 10.1.1 А А эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах 10.1.2 Үйлдвэрлэл үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох өргөтгөх нь зориулан зээл олгох 10.1.3 Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах 10.1.4 Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвөлгөө өгөх, мэдээллээр хангах	
	1.1.2 Ажил олгогчийг дэмжих	11.1 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчидод тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60%-ийг ХЭДС-аас олгоно.	

		11.1.1 16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг 11.1.3 45-аас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн 11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн бүтэн өнчин хүүхэд 11.1.5 ХЭАлбанд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаагаар ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн	11.1.2 Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн 11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
		11.2- Ажилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрээ сургалтанд хамруулж 3 сараас дээш хугацаанд ажлын байраар хангасан ажил олгогчид сургалтын зардлыг ХЭДС-аас нөхөн олгоно.	11.4- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулалыг ажлуулсан хугацааг харгалзан олгоно.
			12[1].3 ХЭА-нд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шалгаруулна.
	1.1.3 Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	12.2 Тухайн орон нутгийн зам, гүүр, далан, суваг, худаг, усжуулалтын системийг байгуулах, засварлах, ой, голын сав, төв суурин газрын бохирдлыг цэвэрлэх, ХБИ-ийн тусгай зориулалтын зам орц, гарцыг барих зэрэг ажлыг ЗДТГ, ААНБ-ын оролцоотойгоор ХЭА зохион байгуулна.	

	1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	12[1].1 ХБИ-ний хөдөлмөрийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, ААН байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех,тасгийн үйл-нд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно 12[1].2 ХЭ-ийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох сорилын аргаар ур чадварыг тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.
5.4 Ажилгүйдлийн тэтгэмж олгох	Энэ тэтгэмжийг НД-ын тухай хуульд заасны дагуу НДШ төлж ажилгүйдлийн даатгалд даатгуулагчид ажлаас гарсан тохиолдолд авна.	Даатгуулагч нь ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд: • 5 хүртэл жил төлсөн 15% • 5-10 жил хүртэл төлсөн 50% • 10-15 жил хүртэл төлсөн 60% • 15 ба түүнээс дээш жил төлсөн 70%

Дүгнэлт: Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” тухай хуулинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны 3 төрлийг дараах байдлаар ангилсныг схемчлэн харуулвал:



Манай улсын энгийн иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг энэ 3 үйл ажиллагаанд аль алинд нь жигд хамрагдуулахаар дээрх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар зохицуулсан байна.

Европ, Азийн зарим орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

Эрх зүйн зохицуулалтын агуулга

1. Нийт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

1.1. Монгол Улс

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль нь 2001 онд батлагдсан бөгөөд хуулийн зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт,

хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хуулийн 5,1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дор дурдсан төрөлтэй байна гэжээ.

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

7.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол явуулж иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцлийн талаар зөвөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.

7.2 Энэ хуулийн 7,1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

8.1 Хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ОН-ийн алба бүртгэж ажилд зуучлана.

8.2 ААНБ-ын хөдөлмөр зуучлалын алба нь төр захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр ажилд зуучлах үйлчилгээ гүйцэтгэж болох бөгөөд тайлан мэдээгээ хөдөлмөр эрхлэлтийн албанд ирүүлнэ.

8.3 Ажлын байрны захиалга, түүнд тавих шаардлагын таөлаарх мэдээлэл ил тод байна.

8.4Ажилд зуучлах төрийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

9.1.1. Эмзэг бүлэгт хамрагдах ажилгүй иргэн

9.1.2 Ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй иргэн

9.1.3 Осол хурц хордлого, мэрэгжлээс шалтгаалах өвчний улмаас мэргэжлээ өөрчлөхийг хүссэн ажил хайгч ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн

9.1.4 Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй болсон иргэн

9.1.5 Тухайн онд ЕБСийн 8,10 анги төгссөн, эсхүл хугацаат цэргийн албанаас халагдсан ажил сургууль гүй иргэн

9.1.7 Сургууль завсардсан, насанд хүрээгүй иргэн

10.1 Хувиараа болон өрхийн АА, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ХЭДС-аас дараахь дэижлэг үзүүлнэ.

10.1.1 А А эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах

10.1.2 Үйлдвэрлэл үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох өргөтгөх нь зориулан зээл олгох

10.1.3 Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах

10.1.4 Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвөлгөө өгөх, мэдээллээр хангах

11.1 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчидод тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60%-ийг ХЭДС-аас олгоно.

11.1.1 16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг

11.1.3 45-аас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн

11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн бүтэн өнчин хүүхэд

11.1.5 ХЭАлбанд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаагаар ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн

11.2 - Ажилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрээ сургалтанд хамруулж 3 сараас дээш хугацаанд ажлын байраар хангасан ажил олгогчид сургалтын зардлыг ХЭДС-аас нөхөн олгоно.

Даатгуулагч нь ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд:

-5 хүртэл жил төлсөн 15%
-5-10 жил хүртэл төлсөн 50%
-10-15 жил хүртэл төлсөн 60%
-15 ба түүнээс дээш жил төлсөн 70%

1.2. Япон Улс

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” 1966

4 дүгээр зүйл. Төрөөс авах арга хэмжээ

4.1 Мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх ажлын байрны үйлчилгээг нэмэгдүүлэх. Энэ ажлыг өөрт тохирсон ажил хийх, ажлын хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах зэргээр хангах;

4.2 Хүн болгон өөрийн ур чадварт тохирсон ур чадварын сургалт, үнэлгээг дэмжих;

4.3 Ажил олгогч нь хэцүү байгаа ажилчдад боломж олгох, ажлаа солихыг зөвшөөрөх;

4.4 Зайлшгүй шалтгааны улмаас ажилгүй болсон ажилтанд өөр ажил олгох;

4.5 Тэтгэвэрийн насыг бага багаар уртасгах;

4.6 Ажиллах нөхцлийг баталгаажуулах зорилгоор ажил олголтын хэлбэр болон бусад асуудлыг сайжруулах;

4.7 Ажилчид өөрсдийнхөө ур чадварыг бүрэн дүүрэн ашиглахад чиглэгдсэн арга хэмжээ авах зэрэг болно.

“Хөдөлмөр эрхлэлтийн аюулгүй байдлын тухай хууль” 1947

4 дүгээр зүйл. Мэргэжлийн зааварчилгаа гэж ажил хайж байгаа хүмүүст тохирсон ажил олох, шинээр ажилд ороход нь практик сургалт, зааварчилгаа, зөвлөгөөг дэмжих үйл ажиллагааг хэлнэ.

20 дугаар зүйл.

Ажил эрхлэлтийн аюулгүй байдлын байгууллага нь ажил хаялт болон зогсолт хийж байгаа байгууллагад шинээр ажил хайж байгаа иргэдийг танилцуулахыг хориглоно.

30 дугаар зүйл. Төлбөртэйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага нь харьяалсан яамнаас тусгай зөвшөөрөл авна.

33 дугаар зүйл. Үнэ төлбөргүйгээр лицензтэй тусгай зөвшөөрөл авна.

1.3. ОХУ

1991 онд батлагдсан “Оросын Холбооны Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай” хуулиар энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг зохицуулжээ.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь төрийн үйлчлгээг үзүүлэхийг хуульчилжээ. Үүнд:

-Иргэдэд өөрт тохирсон ажлаа олж хийхэд нь, ажил олгогчдод шаардлагатай ажилтанаа ажилд авахад нь дэмжлэг үзүүлэх

-ОХУ-ын субъектүүдийн хөдөлмөрийн зах зээлийн байдлын талаар мэдээлэх

-Ажлын байрны болон сургалтын ажлын байрны үзэсгэлэн яармаг зохион байгуулах

-Ажилгүй иргэдийг шинэ мэргэжил эзэмшихэд нь туслах мэргэжлийн сургалт зохион байгуулах, дахин бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх

-Ажилгүй иргэдэд тогтоосон журмын дагуу нийгмийн нөхөн төлбөр олгох

-Төлбөртэй нийгмийн тустай хөдөлмөр зохион байгуулах

-Ажилгүй иргэд ажлын байраа сонгохдоо шууд ажил олгогчтой харьцах буюу хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар үнэ төлбөргүй жуучлуулан ажилтай болох эрхтэй. –

- Иргэд ажлын байр, мэргэжлийн үйл ажиллагааны хүрээгээ сонгохдоо хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар дамжуулан үнэ төлбөргүй мэдээлэл, зөвөлгөө, үйлчилгээ авах, сэтгэл зүйн дэмжлэг, мэргэжлийн бэлтгэл, мэргэжлээ дээшлүүлэх, дахин бэлтгэгдэх эрхтэй. Мөн ажилгүй иргэдэд төрөөс ажилгүйдлийн тэтгэмж олгодог ба түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд энэ тэтгэмж мөн олгогдоно. Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хугацаанд ажилгүй иргэдэд степенд олгодог байна.

1.4. БНКазУлс

БНКазУ-ын 2001 оны “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай хуульд “Төр хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүн амыг ажилгүйдлээс хамгаалахаа баталж байна” хэмээн хуульчилжээ. Энэ хуульд хөдөлмөр эрхлэлтийг нь төрөөс дэмжих зорилтот бүлгийг тодорхойлсон ба энэхүү зорилтот бүлэгт дараах хүмүүс хамаарч байна. Үүнд:

-Орлого багатай хүмүүс

-21 нас хүртэлх залуучууд

-Асрамжийн газар хүмүүжигсэд,

-23 хүртэлх насны өнчин, харах хандах хүнгүй хүүхдүүд

-Олон хүүхэдтэй ганц бие, өрх толгойлсон хүмүүс

-Хуулийн дагуу тогтоогдсон байнгийн асарч хамгаалах шаардлагатай хүнийг асардаг хүмүүс

-Өндөр насны тэтгэвэрт гарах дөхсөн хүмүүс (насны хувьд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 2 жил дутуу байгаа)

-Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

-Хугацаат цэргийн албанаас халагдсан хүмүүс

-Хорих газраас суллагдсан болон албадан эмчилгээнд орсон хүмүүс

-Оралмануудзэрэг болно.

Дээр дурьдсан зорилтот бүлгийн хүмүүст зориулан орон нутгийн захиргааны байгууллага, ажил олгогчидтой гэрээ байгуулан үйлдвэр, албан байгууллага дээр “нийгмийн ажлын байр” бий болгон эдгээр бүлгийн хүмүүсийг ажлын байраар хангадаг ажээ. Гэхдээ энэ ажлын байр нь байнгийн бус түр ажлын байр юм.

БНКазУ-ын төрөөс ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авч байна. Үүнд, нэмэлт ажлын байр бий болгодог жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг харгалзан ажилгүй иргэдийн мэргэжлийн бэлтгэлийг хангах, дахин мэргэшүүлэх уян хатан тогтолцоог бий болгох, олон хүнийг хамарсан нийгмийн тустай хөдөлмөрийг зохион байгуулах,

бүс нутгийнхаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн захиргааны үүргийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг хуулиар зохицуулан хэрэгжүүлж байна.

1.5. Швед Улс

“Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах тухай акт” (1982), “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг ялгаварлан гадуурхахыг хориглох акт”(1999) “Адил тэгш хөдөлмөр эрхлэх боломж акт“ (1991), “Ажилгүйдлийн даатал” (1997), “Ажилгүйдлийн сан” (1997) -уудаар энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг зохицуулжээ.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь зүйлүүдийг хуульчилжээ. Үүнд:

-Хүйсээр ялгаварлахгүй-гээр эрэгтэй, эмэгтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг тэгш байлгах

-Иргэдэд өөрт тохирсон ажлаа олж хийхэд нь, ажил олгогчдод шаардлагатай ажилтанаа ажилд авахад нь дэмжлэг үзүүлэх

-Хүүхэдтэй гэр бүлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (Эцэг эхийн чөлөө олгох Акт-1995)

-Ажлын байрны болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулах

-Сурч боловсрох, цэргийн алба хаах нөхцөлд ажлийн байрыг хадгалах

-Иргэдийг тогтмол ажлын байраар хангахад нь ажил олгогчдыг дэмжих

-Ажилгүй иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн агентлагуудтай хамтран ажиллаж үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах

-Ажилгүй иргэдэд нийгмийн нөхөн төлбөр олгох

-Түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд тэтгэмж олгох

Швед улсад хөдөлмөр эрхэлж буй ажилтан хууль зүйн дараахь гэрээний эрх үүрэгтэй байдаг байна. Үүнд:

-“Эцэг эхийн чөлөө олгох акт”(1995)

-“Адил тэгш хөдөлмөр эрхлэх боломж акт“ (1991)

-“Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977)

-“Үндэс угсаагаар ялгаварлахгүй байх акт “ (1999)

-Шведын нийгмийн хамгаалалын үндсэн зарчим

1.6. Чех Улс

Чех Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг Хөдөлмөр нийгмийн хэргийн яам, хөдөлмөрийн газар эрхэлнэ
(Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль/2004/-ийн 2 дугаар зүйлийн 3-ийн “а”,”б” заалт)

Хүний хөдөлмлөх эрх чөлөөг гарал үүсэл, хүйс, сексийн чиг хандлага, арьсны өнгө, яс үндэс, харъяалал, нийгмийн байдал, төрсөн газар, хэл, эрүүл мэндийн байдал, нас, шашин шүтлэг, итгэл үнэмшил, өмч хөрөнгө, материаллаг эрх, гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, олон нийтийн үүсгэл санаачлагын, улс төрийн нам, бусад хөдөлгөөний, Үйдвэрчний эвлэл, бусад ажилчдын байгууллагын гишүүн гэдгээр нь шууд болон шууд бус аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, Жирэмсэн, хүүхэд хардаг гэх шалтгаанаар болон хүйсийн байдлаар ялгаварлахыг хориглоно. Янз бүрийн харьцаанд өдөөн турхирах, шалгах, хойш тавих, түүнчлэн бодлоготойгоор эдгээр

хэлбэрээр ялгавалахыг хориглоно.(Хөдөлмөр эрхлэлтийн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1-д зааснаар ажил хайж байгаа хүмүүс дор дурдсан тэтгэмж авдаг:

а/ 50 нас хүртэл 6 сарын тэтгэмж;

б/ 50-55 насны хүмүүс 9 сарын тэтгэмж;

в/ 55 –аас дээш насны хүмүүс 12 сарын тэтгэмж;

2. Хөгжлийн бэрхшээл-тэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар

2.1. Монгол Улс

7.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол явуулж иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцлийн талаар зөвөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, **хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг** хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.

7.2 Энэ хуулийн 7,1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

8.5 Хөдөлмөр эрхлэлтийн алба нь ажилд жуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил олгогчтой гэрээ байгуулж. хэрэгжилтэд хяналт тавина.

9.1.6 Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн

10.1 Хувираа болон өрхийн АА, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ХЭДС-аас дараахь дэижлэг үзүүлнэ.

10.1.1 А А эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах

10.1.2 Үйлдвэрлэл үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох өргөтгөх нь зориулан зээл олгох

10.1.3 Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах

10.1.4 Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвөлгөө өгөх, мэдээллээр хангах

11.1 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчидод тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60%-ийг ХЭДС-аас олгоно.

11.1.2 Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн

11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

11.4- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулалыг ажлуулсан хугацааг харгалзан олгоно.

12^{1}.3 ХЭА-нд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шалгаруулна.

12^{1}.1 ХБИ-ний хөдөлмөрийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, ААН байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех,тасгийн үйлдвэрлэлийн тусгай цех,тасгийн үйлдвэрлэлийн тусгай цех,тасгийн

12[1].2 ХЭ-ийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох сорилын аргаар ур чадварыг тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ

Даатгуулагч нь ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд:

-5 хүртэл жил төлсөн 15%
-5 - 10 жил хүртэл төлсөн 50%
-10 - 15 жил хүртэл төлсөн 60%
-15 ба түүнээс дээш жил төлсөн 70%

2.2. Япон

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005

28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад зориулсан тэтгэмж

-Гэр оронд нь очиж үйлчилгээ үзүүлэх;

-Үйл ажиллагааны дэмжлэг, эрүүл мэндийн хамгаалал

-Өдөр тутмын амьдралд үзүүлэх үйлчилгээ;

Хүүхдийн өдрийн халамж, богино хугацаагаар асрах;

Бүлгээр нь асрах байранд байлгах

28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Сургалтын төлбөрын тэтгэлэг:

а/ Нөхөн сэргээх үйлчилгээ;

б/ Хөдөлмөр эрхлэлтэд шилжихийг дэмжих;

в/ Бүлгээр нь дэмжих;

зэрэг тэтгэлгийг орон нутгийн байгууллага шийднэ.

29 дугаар зүйл. Зардлыг нь Эрүүл мэнд, хөдөлмөр,нийгмийн хамгаалалын яам төлнө. Тэтгэлгийг 90 хүртэл хувиар төлөхийг хуулиар тогтоосон.

2.3. ОХУ

Мөн ажилгүй иргэдэд төрөөс ажилгүйдлийн тэтгэмж олгодог ба түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд энэ тэтгэмж мөн олгогдоно. Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хугацаанд ажилгүй иргэдэд степенд олгодог байна.

ОХУ-д холбооны төрийн байгууллагууд болон ОХУ -ын субъектүүдийн төрийн байгууллагуудын зүгээс хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн дараахи тусгай арга хэмжээнүүдийг авах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангадаг байна. Үүнд:

-Өмчлөлийн хэлбэрээс үл хамааран ХБИ-ийг ажилд авахад зориулан тодорхой квот тогтоох, тухайлбал, 100 гаруй ажилтантай байгууллагын нийт ажилчдын 2-оос доошгүй, 4-өөс дээшгүй хувийг нь ХБИ-ээс ажилд авахаар хуульчилсан байна.

-ХБИ-ийг ажиллуулахад зохимжтой ажлын байрыг нөөцөнд байлгах,

-Үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагууд ХБИ-дэд зориулан нэмэлт, түүний дотор тусгай ажлын байр гаргахыг хөхүүлэн дэмжих, тусгай ажлын байр гэдэг нь ХБИ ажиллахад зориулан тэдний онцлогт тохируулсан нэмэлт тоноглол, төхөөрөмж хийх, нэмэлт зохион байгуулалтын арга хэмжээ авахыг хэлдэг байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх хувийн хөтөлбөртэй нь уялдуулан тэдний хөдөлмөрийн нөхцөлийг хангах, бусад ажиллагсадтай харьцуулахад ХБИ-ийн хөдөлмөрийн нөхцөлийг (хөдөлмөрийн хөлс, ажил, амралтын цаг, ээлжийн амралтын хугацаа, хөлс) дордуулсан хамтын болон хувийн хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоно. I, II групптэй хүмүүст долоо хоногийн ажлын өдрийг богиногосон цагаар ажиллуулж (долоо хоногт 35 цагаас дээшгүй), хөдөлмөрийн хөлсийг нь бүрэн олгох ёстой. ХБИ-дэд жил бүр 30 ажлын өдрөөс доошгүй өдрийн ээлжийн амралт олгодог.

-ХБИ-ийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх,

-ХБИ-ийг шинэ мэргэжил эзэмшихэд нь тусламж үзүүлэх

-ХБИ-ийг ажилд авсан болон ажлын байрыг тэдэнд зориулан тусгайлан зохион байгуулсан ажил олгогчдод санхүүгийн хөнгөлөлт үзүүлэх,

-Ажил олгогчид нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан мэдээлэл өгөх, ажлын тусгай байр бий болгох үүрэгтэй.

“Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай” Холбооны хуулийн дагуу 1,2,3 дугаар групптэй хүмүүс тахир дутуугийн тэтгэвэр авдаг ба тэтгэвэрийн хэмжээ нь тогтоосон тахир дутуугийн группээс хамаарна. Үүнд:

-1 дүгээр групп- сард 5124 рубль

-2 дугаар групп- сард 25262 рубль

-3 дугаар групп- сард 1281 рубль

Түүнчлэн тахир дутуугийн тэтгэвэрийн хэмжээг тогтоохдоо хуулийн дагуу тодорхой тохиолдол бүрт бусад шалгуурийг мөн харгалздаг. Түүнчлэн 1999 онд батлагдсан “Төрийн нийгмийн тусламжийн тухай” Холбооны хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр нийгмийн үйлчилгээний төлбөр 641 рублийг олгодог ба үүнээс 570 рубль нь нэмэлт эмнэлгийн тусламж, 71 рубль нь төмөр зам болон эмчилгээний замын зардалд зориулан олгодог байна. ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэлэгийг дор дурдсан хэмжээгээх олгодог байна:

1. Тахир дутуугийн I групп /3 түвшин/

-сар бүрийн мөнгөн төлбөр 2162 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 1521 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 2091 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1592 руб.

2. Тахир дутуугийн II групп /2 түвшин/

-сар бүрийн мөнгөн төлбөр 1544 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 903 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1473 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 904 руб.

3. Тахир дутуугийн IIi групп /1 түвшин/

-сар бүрийн мөнгөн төлбөр 1236 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 595 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1165 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 666 руб.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

-сар бүрийн мөнгөн төлбөр 1544 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 903 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1473 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 904 руб.

5. Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин тогтоогоогүй тахир дутуу хүмүүс

-сар бүрийн мөнгөн төлбөр 772 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 131 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 701 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 202 руб.

Мөн “Оросын Холбооны улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” Холбооны хуульд заасан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууцаар хангагдах, орон сууцны хөлс төлөхөд хөнгөлөлт үзүүлдэг болно.

2.4. Казахстан

БНКазУлсын орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах арга хэмжээг авдаг байна. Үүнд:

-Үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагын нийт ажиллагсдын 3 хувьтай тэнцэх хэмжээний ажлын байрын квотыг ХБИ-д зориулан тогтооно.

-Жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх замаар ХБИ-ийн аж ахуйн үйл ажиллагааг дэмжин нэмэлт ажлын байр бий болгоно.

-Казахстан улсын хууль тогтомжийн дагуу ХБИ-дэд зориулсан ажлын тусгай болон нийгмийн ажлын байрыг бий болгох замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг хангана.

-ХБИ-дэд мэргэжлийн боловсрол олгоно.

-I,II групптэй хүмүүст долоо хоногийн ажлын өдрийг богиногосон цагаар ажиллуулж (долоо хоногт 36 цагаас дээшгүй), хөдөлмөрийн хөлсийг нь бүрэн олгох ёстой. ХБИ-дэд жил бүр 15 хүртэл ажлын өдрийн ээлжийн амралт олгодог.

-ХБИ-ийг өөрийнх нь зөвшөөрсөнөөр, эрүүл мэндэд нь хор учруулахгүйгээр шөнийн цагаар ажиллуулна.

-ХБИ-ийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, ажлаас халах, албан тушаал дэвшүүлэхээс татгалзах зэргийг хориглоно.

-Ажил олгогчийн буруугаас үүдэн тахир дутуу болсон ажиллагсдын ажил эрхлэх нөхцөл, бололцоог хангах (ажлын байрыг тоноглох, орон сууцыг нь тусгай тоног, төхөөрөмжөөр хангах) үүргийн ажил олгогч хүлээнэ.

-Ажил олгогчийн буруугаас үүдэн тахир дутуу болсон иргэдийн шинээр мэргэжил эзэмших, дахин сургах зардлыг ажил олгогч хариуцана.

Казахстан улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын асуудлыг 2005 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”, 1997 онд батлагдсан “Бүгд

Найрамдах Казахстан Улсын тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, өндөр насны нийгмийн тэтгэмжийн тухай" хуулиар тус тус зохицуулж байна.

БНКазУлсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэмж олгохдоо тэдгээрийг 5 ангилалд хуваадаг байна. 1 дүгээр ангилалд өвчний улмаас, хөдөлмөрийн явцад, мэргэжлийн өвчний улмаас тахир дутуу болсон мөн төрөлхийн тахир дутуу хүмүүсийг хамруулдаг ба эдгээрээс тахир дутуугийн 1 дүгээр групптэй хүмүүст сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 2 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,06 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 3 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0,74 –тэй тэнцэх хэмжээний тэтгэмж, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,00–тэй тэнцэх, төрөлхийн тахир дутуу хүүхдэд тахир дутуугийн группээс нь хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36-0,87-тай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна. 3 дугаар ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад хашиж буй албатай нь холбоогүйгээр золгүй явдлын улмаас тахир дутуу болсон цэргийн албан тушаалтнууд мөн тогтоогдсон тарих дутуугийн группээс хамааран 1 дүгээр ахглалын хүмүүстэй ижил хэмжээний иаигамж олгодог.

2, 5 дугаар ангилалын буюу хугацаат цэргийн алба хааж байхдаа тахир дутуу болсон хүмүүс ба иргэний болон цэргийн зориулалттай цөмийн обьект дээр гарсан осолын улмаас, экологийн онцгой байдал, түүний дотор цөмийн дэлбэрэлт, туршилтийн үед цацраг туяаны улмаас тахир дутуу болсон хүмүүст мөн тэдгээрийн тахир дутуугийн группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,61-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна.

4 дүгээр ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад цэргийн албаны үүрэг гүйцэтгэж байхдаа осолын улмаас тахир дутуу болсон цэргийн албан хаагчдад тогтоогдсон группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2, 09-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгож байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн хамгаалал, түүний дотор нөхөн сэргээгдэх, нийгэмтэйгээ хөл нийлүүлэн амьдрах, тоноглогдсон орон байраар хангагдах, үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ хүртэх эрх эдэлдэг.

2.5. Швед

Швед улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тусгай Консул байдаг байна. Швед улсын хувьд хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дараахь тусгай арга хэмжээнүүдийг авдаг байна. Үүнд:

-ХБИ-н ажил олох боломж, ажлын байрны тоо чанарыг нэмэгдүүлэхийн тулд төрөөс тусгайлан зориулсан хөтөлбөрүүд зохион байгуулдаг. (хөдөлмөрлөх бэлтгэлтэй болгох нөхөн сэргээх хөтөлбөр; төрөл бүрийн техник мэргэжилийн сургалтад хамруулах хөтөлбөр гэх мэт)

-Ажиллах орчин нь аль ч хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хялбар дөхөм байх

-Ажил олгогч нь ажилд орох хүсэлт тавьсан ХБИ-г болон ХБ ажилтанг ялгаварлан гадуурхахгүй байх

-ХБИ-ийн техник, мэргэжлийн дадлагад хамруулах

-ХБИ-ийг шинэ мэргэжил эзэмшихэд нь тусламж үзүүлэх

-Ажил олгогчид нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан мэдээлэл өгөх, ажлын тусгай байр бий болгох, нэгдсэн журмаар зохион байгуулж буй сургалт, семинарт хамруулах үүрэгтэй.

Швед улсын Үндэсний Статистикаас 2007 онд гаргасан судалгаагаар Швед улсын хүн амын 18,8 хувь буюу 1 сая орчим 16 - 64 насны иргэд ямар нэгэн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй гэжээ. Эдгээрээс ойролцоогоор 600 мянган хүн нь хөдөлмөрийн чадвар буурсан гэсэн тоо гарчээ. ХБИ-н хөдөлмөр эрхэлж байгаа ажлын төрөл чанарыг нь авч үзэхэд дээд боловсрол шаарддаггүй барилга болон аж үйлдэрийн салбарууд байна.

2.6. Чех Улс

Хөдөлмөр эрхлэлтийн хуулийн 67 дугаар зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 3 ангилалд хуваж үздэг :

а/ Бүрэн тахир дутуу;

б/ Хагас тахир дутуу;

в/ Тахир дутуугийн зэрэглэл буурсан;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд сургах, давтан сургах , нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийн газраас санхүүжүүлэхээр мөн хуульд заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулахад тохиромжтой ажлын барыг нөөцөд байлгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилуулж байгаа аж ахуйн нэгжийн татвар, хураамжийг хөнгөлж байхаар заасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 78 дугаар зүйлд ний т ажиллах хүчнийх нь 50-иас дээш хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг ажил олгогчид хуанлийн жилийг 4 хуваасны 3-ын эхэнд тэтгэлэг олгох бөгөөд тэтгэлэгийн хэмжээ нь бүрэн тахир дутуу ажилтан бүрт улсын хэмжээний дундаж цалингийн 0.66, бусад тахир дутуу иргэний хувьд 0.33 байхаар зохицуулж, тэтгэлэг олгох нөхцөл журмыг тогтоосон байна. Мөн хуулийн 81 дүгээр зүйлийн 1-д 25-аас дээш ажлын байртай ажил олгогч нийт ажлын байрны 4 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулахаар зохицуулсан байна.

Мөн хуулийн 82 дугаар зүйлд Хуанлийн жилийг 4 хуваасны 3-ын эхэнд хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд улсын төсвөөс үнэсний хэмжээнд тогтоосон сарын духдаж цалинг 2.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөрийг заавал олгоно. Түүнчлэн ажил олгогч нь хөдөлмөрийн чадвараа алдсан тахир дутуу иргэнийг ажиллуулах үүрэгтэй гэж заажээ.